



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/158/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Г МАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ Г
БОЛОВСРОЛЫН НЭГДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ж.ТӨМӨРЧӨДӨР ТАНАА

8026.02.25 № СЭА-2026/158/НА-СТА-ТШЗ

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Боловсролын яамнаас 26,089.8 мянган төгрөгийн ном сурах бичиг, зөөврийн компьютер, угаалгын машин, ухаалаг самбар зэрэг тоног төхөөрөмжийг, “Адра Монгол” олон улсын байгууллага нь хандиваар 9,750.0 мянган төгрөгийн ногооны хүлэмж, газар бутлагч төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээлгэн өгсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн

хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 36 зорилтын хүрээнд 115 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тод-руулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	135,794,855.53	13,731,414.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө			
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		135,794,855.53	13,731,414.00
3121	Төгрөг		135,794,855.53	13,731,414.00
31211	Төрийн сангийн харилцах		135,794,855.53	13,731,414.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6	220,822,800.94	234,951,980.14
351	Түүхий эд материал		47,753,640.37	62,857,019.57
3511	Тусгай зориулалттай материал		47,626,405.37	62,591,784.57
3513	Эм боох материал		127,235.00	265,235.00
354	Хангамжийн материал		173,069,160.57	172,094,960.57
3541	Бичиг хэргийн материал		774,888.00	214,488.00
3547	Бусад хангамжийн материал		172,294,272.57	171,880,472.57
36	НӨӨЦИЙН БАРАА			
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		356,617,656.47	248,683,394.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	4,352,062,466.88	4,331,083,488.02
392	Биет хөрөнгө		3,207,886,466.88	3,184,704,856.02
39201	Барилга, байгууламж, орон сууц		2,450,570,067.00	2,450,570,067.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(510,546,607.92)	(614,063,353.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		6,750,000.00	6,750,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(6,750,000.00)	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		898,313,546.83	953,239,546.83
39206	Хуримтлагдсан элэгдэл		(242,412,143.76)	(285,722,467.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		228,251,088.18	250,711,088.18
39208	Хуримтлагдсан элэгдэл		(137,509,052.75)	(77,395,043.02)
39214	Бусад үндсэн хөрөнгө		534,428,272.03	540,678,272.03
39215	Хуримтлагдсан элэгдэл		(101,035,048.01)	(132,659,376.33)
39217	Ном		87,826,345.28	92,596,122.32
393	Биет бус хөрөнгө		1,144,176,000.00	1,146,378,632.00
39301	Програм хангамж		2,202,632.00	2,202,632.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(2,202,632.00)	
39303	Бусад биет бус хөрөнгө		1,144,176,000.00	1,144,176,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		4,352,062,466.88	4,331,083,488.02
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		4,708,680,123.35	4,579,766,882.16
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	704,744.78	67,046,992.44
413	Өглөг		704,744.78	67,046,992.44
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		704,744.78	65,507,892.44
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг			1,539,100.00
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		704,744.78	67,046,992.44
51	Засгийн газрын хувь оролцоо		4,707,975,378.57	4,512,719,889.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		2,367,675,453.39	2,367,675,453.39
51101	Өмч: - төрийн		2,367,675,453.39	2,367,675,453.39
512	Хуримтлагдсан үр дүн		781,084,654.07	586,609,495.98
5121	Өмнөх үеийн үр дүн		781,084,654.07	781,864,984.83
5122	Тайлант үеийн үр дүн			(195,255,488.85)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,559,215,271.11	1,558,434,940.35
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,707,975,378.57	4,512,719,889.72
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		4,708,680,123.35	4,579,766,882.16

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,574,660,362.77	4,324,966,545.57
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		3,372,976,300.00	4,080,561,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		3,372,976,300.00	4,080,561,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		201,684,062.77	244,405,145.57
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		201,684,062.77	244,405,145.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		984,225,561.88	324,056,774.79
120	Нийтлэг татварын бус орлого		984,225,561.88	324,056,774.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		27,096,200.00	19,577,480.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		15,996,200.00	14,776,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		11,100,000.00	4,800,980.00
120009	Бусад орлого			61,601.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		948,124,738.38	289,542,314.59
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		9,004,623.50	14,875,379.20
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	4,558,885,924.65	4,649,023,320.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,846,347,589.14	4,844,278,809.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,724,861,489.14	4,684,167,259.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,782,283,556.00	3,454,905,210.00
210101	Үндсэн цалин		1,641,717,620.00	1,883,151,517.00
210102	Нэмэгдэл		1,026,734,581.00	1,369,556,219.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт			100,936,143.00
210104	Урамшуулал		113,831,355.00	101,261,331.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		343,851,637.74	421,774,560.66
210201	Тэтгэврийн даатгал		231,980,058.44	286,575,940.66
210202	Тэтгэмжийн даатгал		28,058,676.73	33,799,580.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		14,636,172.27	16,899,790.00
210204	Ажилгүйдлийн даатгал		13,775,205.64	16,899,790.00
210205	Эрүүл мэндийн даатгал		55,401,524.66	67,599,460.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		193,791,462.77	237,405,145.57
210301	Гэрэл, цахилгаан		41,090,432.77	48,954,651.57
210302	Түлш, халаалт		134,520,260.00	163,637,180.00
210303	Цэвэр, бохир ус		18,180,770.00	24,813,314.00
2104	Хангамж, бараа материалын зардал		16,125,832.00	
210408	Бараа материал акталсны зардал		16,125,832.00	
2105	Нормативт зардал		50,534,500.00	73,027,350.00
210502	Хоол, хүнс		50,534,500.00	73,027,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		7,892,600.00	7,000,000.00
210604	Урсгал засвар		7,892,600.00	7,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		39,277,653.71	48,518,062.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		7,596,200.00	3,677,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		31,681,453.71	44,841,062.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		291,104,246.92	441,536,930.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		68,670,052.00	61,061,672.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		25,619,700.00	17,387,965.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		196,814,494.92	363,087,293.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		121,486,100.00	160,111,550.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		121,486,100.00	160,111,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		109,303,800.00	160,111,550.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		12,182,300.00	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	3,846,347,589.14	4,844,278,809.21
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		712,538,335.51	(195,255,488.85)
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		712,538,335.51	(195,255,488.85)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,601,756,562.77	4,344,605,626.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,096,200.00	19,639,081.00
120	Нийтлэг татварын бус орлого	27,096,200.00	19,639,081.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,096,200.00	19,577,480.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,996,200.00	14,776,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,100,000.00	4,800,980.00
120009	Бусад орлого		61,601.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,574,660,362.77	4,324,966,545.57
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,372,976,300.00	4,080,561,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,372,976,300.00	4,080,561,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	201,684,062.77	244,405,145.57
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	201,684,062.77	244,405,145.57
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,641,558,257.44	4,414,103,068.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,641,558,257.44	4,414,103,068.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,520,072,157.44	4,253,991,518.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,782,283,556.00	3,389,397,318.00
210101	Үндсэн цалин	1,641,717,620.00	1,840,541,517.00
210102	Нэмэгдэл	1,026,734,581.00	1,360,961,127.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		86,633,343.00
210104	Урамшуулал	113,831,355.00	101,261,331.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	343,146,892.96	422,479,305.00
210201	Тэтгэврийн даатгал	231,275,313.66	287,280,685.00
210202	Тэтгэмжийн даатгал	28,058,676.73	33,799,580.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,636,172.27	16,899,790.00
210204	Ажилгүйдлийн даатгал	13,775,205.64	16,899,790.00
210205	Эрүүл мэндийн даатгал	55,401,524.66	67,599,460.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	193,791,462.77	237,405,145.57
210301	Гэрэл, цахилгаан	41,090,432.77	48,954,651.57
210302	Түлш, халаалт	134,520,260.00	163,637,180.00
210303	Цэвэр, бохир ус	18,180,770.00	24,813,314.00
2105	Нормативт зардал	50,534,500.00	73,027,350.00
210502	Хоол, хүнс	50,534,500.00	73,027,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,892,600.00	7,000,000.00
210604	Урсгал засвар	7,892,600.00	7,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,277,653.71	48,518,062.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,596,200.00	3,677,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,681,453.71	44,841,062.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,145,492.00	76,164,337.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	77,525,792.00	58,305,972.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,619,700.00	17,858,365.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,486,100.00	160,111,550.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	121,486,100.00	160,111,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	109,303,800.00	160,111,550.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,182,300.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(39,801,694.67)	(69,497,441.53)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	84,333,000.00	52,566,000.00
222001	Дотоод эх үүсвэрээр	84,333,000.00	52,566,000.00
222001	Тонг төхөөрөмж	68,638,000.00	33,796,000.00
223001	Бусад хөрөнгө	15,695,000.00	18,770,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(84,333,000.00)	(52,566,000.00)
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(124,134,694.67)	(122,063,441.53)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		135,794,855.53
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		13,731,414.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,367,675,453.39	1,559,215,271.11	781,084,654.07	4,707,975,378.57
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	780,330.76	780,330.76
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(780,330.76)	-	(780,330.76)
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн	-	-	(195,255,488.85)	(195,255,488.85)
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,367,675,453.39	1,558,434,940.35	586,609,495.98	4,512,719,889.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	4,531,025,100.00	4,324,966,545.57	206,058,554.43	95.5
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,247,734,900.00	4,080,561,400.00	167,173,500.00	96.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,116,549,800.00	4,080,561,400.00	35,988,400.00	99.1
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	131,185,100.00		131,185,100.00	-
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	283,290,200.00	244,405,145.57	38,885,054.43	86.3
132001	Орон нутгийн төсвөөс	283,290,200.00	244,405,145.57	38,885,054.43	86.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	19,572,600.00	19,577,480.00	(4,880.00)	100.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,776,600.00	14,776,500.00	100.00	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,796,000.00	4,800,980.00	(4,980.00)	100.1
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,550,597,700.00	4,344,605,626.57	205,992,073.43	95.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,546,920,700.00	4,466,669,068.10	80,251,631.90	98.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,381,414,500.00	4,306,557,518.10	74,856,981.90	98.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,407,761,800.00	3,389,397,318.00	18,364,482.00	99.5
210101	Үндсэн цалин	1,995,744,900.00	1,840,541,517.00	155,203,383.00	92.2
210102	Нэмэгдэл	1,339,934,800.00	1,360,961,127.00	(21,026,327.00)	101.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт		86,633,343.00	(86,633,343.00)	
210104	Урамшуулал	72,082,100.00	101,261,331.00	(29,179,231.00)	140.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	425,970,200.00	422,479,305.00	3,490,895.00	99.2
210201	Тэтгэврийн даатгал	289,659,700.00	287,280,685.00	2,379,015.00	99.2
210202	Тэтгэмжийн даатгал	34,077,700.00	33,799,580.00	278,120.00	99.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,038,800.00	16,899,790.00	139,010.00	99.2
210204	Ажилгүйдлийн даатгал	17,038,800.00	16,899,790.00	139,010.00	99.2
210205	Эрүүл мэндийн даатгал	68,155,200.00	67,599,460.00	555,740.00	99.2

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	276,290,200.00	237,405,145.57	38,885,054.43	85.9
210301	Гэрэл, цахилгаан	67,582,300.00	48,954,651.57	18,627,648.43	72.4
210302	Түлш, халаалт	183,417,300.00	163,637,180.00	19,780,120.00	89.2
210303	Цэвэр, бохир ус	25,290,600.00	24,813,314.00	477,286.00	98.1
2105	Нормативт зардал	81,086,900.00	73,027,350.00	8,059,550.00	90.1
210502	Хоол, хүнс	81,086,900.00	73,027,350.00	8,059,550.00	90.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,000,000.00	7,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	7,000,000.00	7,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,647,400.00	48,518,062.53	1,129,337.47	97.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,677,000.00	(3,677,000.00)	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	49,647,400.00	44,841,062.53	4,806,337.47	90.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133,658,000.00	128,730,337.00	4,927,663.00	96.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	115,100,200.00	110,871,972.00	4,228,228.00	96.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,557,800.00	17,858,365.00	699,435.00	96.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	165,506,200.00	160,111,550.00	5,394,650.00	96.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	165,506,200.00	160,111,550.00	5,394,650.00	96.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	165,506,200.00	160,111,550.00	5,394,650.00	96.7
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,546,920,700.00	4,466,669,068.10	80,251,631.90	98.2
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		135,794,855.53	(135,794,855.53)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		13,731,414.00	(13,731,414.00)	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО		1	1	
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО		117	115	
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 482,801.4 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 245 нэр төрлийн 194,686.6 мянган төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй,
- Барилга дансанд бүртгэлтэй 284,311.0 мянган төгрөгийн спорт заалны их засварыг капиталжуулалгүйгээр тусдаа 1 хөрөнгө мэтээр бүртгэсэн,
- Тайлант онд 10,847.7 мянган төгрөгийн 7 эд хогшлын ашиглалтын хугацааг буруу болон огт оруулж өгөөгүйгээс элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга”-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг

үнэн зөв толилуулах ёстой...”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн ХЗУ¹4-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй ...”, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **35,443.1** мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс 1,173.7 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 369.4 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, биет бус хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 33,900.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **1,543.1** мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 36,920.4 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

1. Хоол зүйч Д.Болор-Эрдэнэд тогоочийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 20 хувиар тооцож 1,173.7 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 6 дахь “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдлийг зөвхөн тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа хугацаанд нь олгоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

1. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 3 ажилтанд 369.4 мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Биеэр бүрэн эдлээгүй ээлжийн амралтыг нөхөн эдлүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Биет бус хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Тухайн байгууллагын эзэмшилд буй 7 газрын хэмжээ нь газрын гэрчилгээнд 68349 м² гэж бүртгэгдсэн боловч санхүүгийн тайланд 70232 м² буюу зөрүүтэй бүртгэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх,

¹ ХЗУ-Хэрэгжүүлэх заавар удирдамж

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Биет бус хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн, зөв дүнгээр тусгаж байх зөвлөмж хүргүүлээ.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй	1	194,686.6	1	194,686.6			1	194,686.6				
Спорт заалны их засварыг капиталжуулалгүйгээр тусад нь бүртгэсэн	1	284,311.0			1	284,311.0	1	284,311.0				
Элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан	1	3,803.8			1	3,803.8	1	3,803.8				
Дүн	3	482,801.4	1	194,686.6	2	288,144.8	3	482,144.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хоол зүйчд тогоочийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгосон	1	1,173.7	1	1,173.7								

Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс цалинг давхардуулан бодож олгосон	1	369.4			1	369.4				
Биет бус хөрөнгийн бүртгэлд газрын тоо хэмжээг буруу бүртгэсэн	1	33,900.0					1	33,900.0		
Дүн	3	35,443.1	1	1,173.7	1	369.4	1	33,900.0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Дүн								
Нийт дүн								

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			